# Тогтвортой санхүүгийн чиг хандлага

**Э.Номиндарь, ТоС Холбооны гүйцэтгэх захирал**

СЗХ-нд зориулав

2023.10.26

# Гишүүд

## 2017 үүсгэн байгуулагдсан
## 37 гишүүн (2023 оны 10 сарын байдлаар)

Банк (12)

Хөгжлийн банк (1)

МИК (1)

Зээлийн батлан даалтын сан (1)

ББСБ (14)

Даатгалын компани (1)

ҮЦК (2)

Бизнесийн байгууллага (3)

Судалгаа, сургалтын төв (2)

# 1.1

# Олон улсын чиг хандлага



# Хүн төрөлхтөнд тулгарч буй хамгийн том эрсдэлүүд юу вэ?

Дэлхийн эдийн засгийн форум жил бүр дэлхийн эрсдэлийн тайланг гаргадаг

# Эдгээр нь хүн төрөлхтөнд тулгарч буй хамгийн том эрсдэлүүд юм

**Эрсдэлийн мөн чанар хувьсан өөрчлөгдөж байна 2012-2021**

**Гол томоохон эрсдэлүүд нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байна.**



Top Global Risks by Likelihood

| | 1st | 2nd | 3rd | 4th | 5th |
|---|---|---|---|---|---|
| 2021 | Extreme weather | Climate action failure | Human environmental damage | Infectious diseases | Biodiversity loss |
| 2020 | Extreme weather | Climate action failure | Natural disasters | Biodiversity loss | Human-made environmental disasters |
| 2019 | Extreme weather | Climate action failure | Natural disasters | Data fraud or theft | Cyberattacks |
| 2018 | Extreme weather | Natural disasters | Cyberattacks | Data fraud or theft | Climate action failure |
| 2017 | Extreme weather | Involuntary migration | Natural disasters | Terrorist attacks | Data fraud or theft |
| 2016 | Involuntary migration | Extreme weather | Climate action failure | Interstate conflict | Natural catastrophes |
| 2015 | Interstate conflict | Extreme weather | Failure of national governance | State collapse or crisis | Unemployment |
| 2014 | Income disparity | Extreme weather | Unemployment | Climate action failure | Cyberattacks |
| 2013 | Income disparity | Fiscal imbalances | Greenhouse gas emissions | Water crises | Population ageing |
| 2012 | Income disparity | Fiscal imbalances | Greenhouse gas emissions | Cyberattacks | Water crises |

Top Global Risks by Impact

| | 1st | 2nd | 3rd | 4th | 5th |
|---|---|---|---|---|---|
| 2021 | Infectious diseases | Climate action failure | Weapons of mass destruction | Biodiversity loss | Natural resource crises |
| 2020 | Climate action failure | Weapons of mass destruction | Biodiversity loss | Extreme weather | Water crises |
| 2019 | Weapons of mass destruction | Climate action failure | Extreme weather | Water crises | Natural disasters |
| 2018 | Weapons of mass destruction | Extreme weather | Natural disasters | Climate action failure | Water crises |
| 2017 | Weapons of mass destruction | Extreme weather | Water crises | Natural disasters | Climate action failure |
| 2016 | Climate action failure | Weapons of mass destruction | Water crises | Involuntary migration | Energy price shock |
| 2015 | Water crises | Infectious diseases | Weapons of mass destruction | Interstate conflict | Climate action failure |
| 2014 | Fiscal crises | Climate action failure | Water crises | Unemployment | Infrastructure breakdown |
| 2013 | Financial failure | Water crises | Fiscal imbalances | Weapons of mass destruction | Climate action failure |
| 2012 | Financial failure | Water crises | Food crises | Fiscal imbalances | Energy price volatility |

Source: WEF

Economic · Environmental · Geopolitical · Societal · Technological

# Тогтвортой байдалтай холбоотой бий болж буй томоохон асуудлууд




Байгалийн нөөц, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдал, нийгмийн тогтвортой байдал зэрэг нь бизнесүүдийн ашигт ажиллагаанд нөлөөлөх суурь асуудлууд болсон байна!

# Тогтвортой хөгжлийн талаар яагаад ярих болов?

**Энэ асуудлыг дэлхий нийтээр анхаарч эхэлсэн**







COP21 · CMP11
PARIS 2015
UN CLIMATE CHANGE CONFERENCE

SUSTAINABLE DEVELOPMENT GOALS

# Тогтвортой санхүүгийн хөгжил



# Тогтвортой санхүүгийн хоёр гол зорилгууд




**Эрсдэлийг бууруулах**

**Тогтвортой санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх**

Хандлага: Санхүүгийн салбарт БОНЗ болон уур амьсгалын эрсдэлийн удирдлага, тайлагналын арга ажиллагааг нэвтрүүлэх

Хандлага: Ногоон бонд, тогтвортой байдалтай холбоотой зээл зэрэг холбогдох хэрэгслүүдээр дамжуулан тогтвортой хөгжлийн зорилтуудад нийцсэн эдийн засгийн салбар, үйл ажиллагааг санхүүжүүлэх санхүүжилтийн боломжийг нээх.

Эх сурвалж: ОУСК – Тогтвортой банк санхүүгийн байгууллагуудын холбоо

# Тогтвортой санхүүгийн тодорхойлолт

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг санхүүжүүлэх (асуудал)

| Байгаль орчны | | | Нийгмийн | Засаглал | Эдийн засгийн |
|---|---|---|---|---|---|
| Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой сөрөг нөлөөг бууруулах | Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох | Жишээлбэл: Биологийн олон янз байдал, нөөцийн үр ашиг, экосистем, бохирдлоос урьдчилан сэргийлэх, циркулар эдийн засаг | Жишээлбэл: ЖДБ, жендер, эрүүл мэнд, хүний эрх, ХХАБ, нийгмийн эмзэг бүлэг, залуучууд, соёлын өв | Жишээлбэл: ТУЗ-ийн хяналт, хувьцаа эзэмшигчдийн эрх, ил тод байдал, тайлагнал | Эдийн засаг: Жишээлбэл: Татвар, нийлүүлэлтийн сүлжээ, ажлын байр, орлого бий болгох үйл ажиллагаа |

**Байгаль орчин, нийгэм, засаглал**

**Ногоон санхүүжилт**

**Уур амьсгалын санхүүжилт**

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн санхүүжилт

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход чиглэсэн санхүүжилт

**Уур амьсгалын шилжилтийн санхүүжилт**

ТБСБХ-ны гишүүдийн туршлагаас харахад энэ чиглэлээр ажиллаж эхэлж байгаа ихэнх улс орнууд эхлээд голдуу "БОНЗ", "ногоон" эсвэл "уур амьсгалын өөрчлөлт" гэсэн нэн яаралтай, тулгамдсан асуудлууд дээр төвлөрдөг ба цаг хугацаа өнгөрөх тусам яваандаа нийгмийн болон тогтвортой байдлын зорилтуудтай холбоотой бусад өргөн хүрээтэй асуудлуудыг хамрах байдлаар үйл ажиллагаа нь өргөжих хандлагатай байдаг.

# Тогтвортой санхүүгийн санаачлага ба стандартууд

**Санхүүгийн салбарт тогтвортой байдлын чиглэлээр олон төрлийн санал санаачлагууд хурдацтай хөгжсөөр байна**



# Санхүүгийн байгууллагууд яагаад энэ асуудлыг анхаарах ёстой вэ?



# Санхүүгийн байгууллагуудын хувьд гол шалтгаан юу байх вэ?

**Дэлхий нийтийн өмнөө тавьсан зорилгыг биелүүлэхийн тулд бүх талуудтай хамтран ажиллах шаардлага**

**Эрсдэлийн удирдлага ба санхүүгийн салбарын тогтвортой байдал**

**Өсөн нэмэгдэж буй хөрөнгө оруулалт ба зах зээлийн шинэ боломжууд**

**Хувьсан өөрчлөгдөж буй зах зээл ба зохицуулалтын орчин**

**Эдгээр асуудлуудыг тус бүрд нь дэлгэрэнгүй авч үзье....**

# Бүх талуудтай хамтран ажиллах шаардлага

**2030 он гэхэд уур амьсгалтай холбоотой олон улсын хэмжээнд тохиролцсон зорилтуудыг биелүүлэх, мөн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд шаардлагатай санхүүжилтийн хэмжээг жил бүр дор хаяж 590% нэмэгдүүлэх шаардлагатай.**




Эх сурвалж: Уур амьсгалын бодлогын санаачлага

# Бүх талуудтай хамтран ажиллах шаардлага




Хэдийгээр санхүүгийн салбар нь БОНЗ болон уур амьсгалын асуудалд шууд байдлаар нөлөө үзүүлэх нь хязгаарлагдмал боловч харилцагчид, зээлдэгчиддээ илүү тогтвортой бизнесийн үйл ажиллагаа руу шилжихэд нь туслах, түүнчлэн нүүрстөрөгч багатай, хүртээмжтэй эдийн засгийг бий болгоход гол үүрэг гүйцэтгэх боломжтой!

# Эрсдэлийн удирдлага (БОНЗ)



- **Байгаль орчны эрсдэл**: Биет эрсдэл (нийлүүлэлтийн сүлжээ доголдох/далайн усны түвшин нэмэгдэх/ган гачиг гэх мэт) болон Шилжилтийн эрсдэл (Тогтвортой байдлыг дэмжих зорилгоор хууль тогтоогч/зохицуулагч байгууллагын гаргаж буй шинэ дүрэм журам, шаардлага)
- **Нийгмийн эрсдэл** (хөдөлмөрийн стандартыг дагаж мөрдөхгүй байх/ хөдөлмөрийн хөлс хангалтгүй байх/ ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй байх)
- **Засаглалын эрсдэл** (холбогдох хууль журмыг зөрчих, авлига, хээл хахууль авах)

# Эрсдэлийн удирдлага (БОНЗ)

**Тогтвортой санхүү яагаад санхүүгийн байгууллагуудад чухал вэ?**




Байгаль орчин,
нийгмийн хүчин зүйлтэй
холбоотой эрсдэл

# Эрсдэлийн удирдлага (уур амьсгалын эрсдэл)

**Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор улс орнуудын гаргаж буй амлалт, зорилтууд – хүлэмжийн хийн ялгаруулалтыг нэт зеро байлгах**

Дэлхийн хүлэмжийн хийн нийт ялгаруулалтын 74.2 хувийг эзэлдэг 82 улс орнууд хүлэмжийн хийн ялгаруулалтыг нэт зеро байлгах зорилт дэвшүүлсэн байна.






Source: WRI

# Эрсдэлийн удирдлага (уур амьсгалын эрсдэл)

Хятад улс өөрийн улс болон гадаад улс орнуудад шинээр нүүрсний эрчим хүчний үйлдвэр барихаа зогсоох амлалт өгсөн

2 их наяд ам.долларын хөрөнгө "аюултай" салбарт байна: чулуужсан түлшний салбарт ажилладаг компаниуд хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын өгөөжийг байхгүй болгох эрсдэлтэй тулгарч байна

Climate change




Xi Jinping made his address in a video recording at the annual summit






# Хөрөнгө оруулалтын өсөн нэмэгдэж буй боломжууд

## EIB

European Investment Bank

- 2021 оноос хойших бүх шинэ санхүүжилт 100% Парис хэлэлцээрийн зорилтуудтай нийцсэн байх
- 2025 оноос хойш өөрийн багц дах ногоон санхүүжилтийн хэмжээг 50% дээш болгох
- 2021-2030 онуудын хооронд 1 их наяд Еврог уур амьсгалын санхүүжилтэд зарцуулах

## EBRD

European Bank for Reconstruction and Development

- 2022 оны сүүлчээс хойших бүх үйл ажиллагаа 100% Парис хэлэлцээрийн зорилтуудтай нийцсэн байх
- 2025 оноос хойш өөрийн багц дах ногоон санхүүжилтийн хэмжээг 50% дээш болгох
- Жил бүр 25-40 сая тонн хүлэмжийн хийг бууруулахад шаардагдах санхүүжилт олгох

## ADB

ADB ASIAN DEVELOPMENT BANK

- 2023.7 сар гэхэд 3Г төслүүдийг 100%, хувийн хэвшлийн төслүүдийн 85%-г тус тус Парис хэлэлцээрийн зорилтуудтай нийцүүлсэн байх
- 2019-2030 онуудын хооронд нийт 100 тэрбум ам.долларын уур амьсгалын санхүүжилтийг хөгжиж буй орнуудад олгох

## IFC

IFC International Finance Corporation WORLD BANK GROUP

- 2023.7 сар гэхэд шинэ зээлүүдийн 85%, 2025 оны 7 сар гэхэд бүх үйл ажиллагаа 100% Парис хэлэлцээрийн зорилтуудтай нийцсэн байх

## AFDB

- Парис хэлэлцээрийн зорилтуудтай нийцсэн байх
- Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох болон сөрөг нөлөөг бууруулахад чиглэсэн төслүүдийг санхүүжүүлэхэд 25 тэрбум ам.доллар олгох

# Хөрөнгө оруулалтын өсөн нэмэгдэж буй боломжууд




**86**
*Asset Owners*

**$ 11tr**
*Assets under Management*

**44**
*Members with set target*

**US$ 7.1tr**
*Under the target-setting framework*

Allianz
Caisse des Dépôts GROUPE
CDPQ
Folksam
PensionDanmark
Swiss Re
alecta
AMF
CalPERS
Nordea Life and Pension
storebrand
ZURICH

GSS+ debt volume surpassed USD1tn in 2021




Source: Climate Bonds Initiative

# Хөрөнгө оруулалтын өсөн нэмэгдэж буй боломжууд

### Цар тахлын дараах эдийн засгийг сэргээх бодлогын нөлөө

ЕХ болон АНУ эдийн засгаа сэргээх, COVID-19 хямралын дараах нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах үйл явцыг эхлүүлэхийн тулд их хэмжээний ногоон хөрөнгө оруулалт хийхээ мэдэгдсэн. Тиймээс сэргээгдэх эрчим хүчний өртгийг бууруулж, нүүрстөрөгчийг их хэмжээгээр ялгаруулдаг улс орнуудаас ирэх бараа материалын импортын татварыг нэмэгдүүлэх бодлого баримтална.

### Сэргээгдэх эрчим хүчний үнэ буурч байна

Нүүрстөрөгчийн ялгаруулалтыг бууруулах тооцоолол тасралтгүй хувьсан өөрчлөгдөж байна.

2020 оны 10-р сард Олон улсын эрчим хүчний агентлагийн зүгээс “Одоогоор зах зээл дээр байгаа нарны эрчим хүчний технологиуд нь “түүхэн дэх хамгийн хямд цахилгаан эх үүсвэрийг” санал болгож байна гэж дүгнэжээ.

### Бизнесүүд улам ихээр ногоон болох хандлагатай байна

TESLA гэх мэт компаниудын зах зээл дээрх хувьцааны үнэ огцом өсөж, EXXON зэрэг компаниудын хувьцааны ханш унах дүр зураг ажиглагдаж байна

Компаниуд санхүүгийн шийдвэртээ уур амьсгалын эрсдэлийг тусгах байдал улам нэмэгдэж байна

Компаниуд болон хөрөнгө оруулагчид өөрсдийн үйл ажиллагаа нь уур амьсгалын шилжилтийн зорилтуудтай нийцэж байгааг харуулах, тайлагнах шаардлагатай болж байна

Одоогийн байдлаар олон улсын хэмжээнд 70 улс орнуудын төв банкнууд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна

# Зохицуулалтын орчин хувьсан өөрчлөгдөж байна

## Тогтвортой санхүүтэй холбоотой зохицуулалтын арга хэмжээнүүд хөгжингүй болон хөгжиж буй зах зээлүүдэд хурдацтай хөгжиж байна




Эх сурвалж: ОУСК- Тогвортой банк санхүүгийн байгууллагуудын холбоо




*Source:* UNCTAD.
*Note:* Other selected economies include Switzerland, as well as 13 developing economies (Bangladesh, Chile, Colombia, Egypt, Hong Kong (China), Kenya, Malaysia, Nigeria, the Philippines, Singapore, Thailand, the United Arab Emirates and Viet Nam), and ASEAN. Relevant measures of the EU are included in the number for the G20.

# Зохицуулалтын орчин хувьсан өөрчлөгдөж байна




Source: IFRS Foundation




- S1: TCFD-д нийцсэн тайлагналын болон ил тод байдлын шаардлагууд: засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага, хэмжигдэхүүн ба зорилтууд (SASB)
- S2: Эрсдэл ба боломжуудын талаарх мэдээллийг агуулсан уур амьсгалтай холбоотой ил тод байдлын тайлагнал

- Шилжилтийн төлөвлөлт
- Уур амьсгалийн өөрчлөлтөд тэсвэртэй байдал
- Хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох 1-3 хамрах хүрээ

# Зохицуулалтын орчин хувьсан өөрчлөгдөж байна

- **S1: TCFD-д нийцсэн тайлагналын болон ил тод байдлын шаардлагууд: засаглал, стратеги, эрсдэлийн удирдлага, хэмжигдэхүүн ба зорилтууд (SASB)**
  - ТУЗ-ын оролцоо (хариуцсан хороо, тайлагнал, чадавх, шийдвэр гаргалт, шагнал урамшууллын бодлого)
  - гүйцэтгэх удирдлагын баг (албан тушаал, хороо, дотоод хяналт)
  - эрсдэл, боломж, нөлөөллийн үнэлгээ (санхүүгийн байдалд үзүүлэх нөлөө)
  - эрсдэлийн удирдлага
  - стратеги (бууруулах болон дасан зохицох)
  - тайлагнал, СТОУС индикатор болон бусад индикатор

- **S2: Эрсдэл ба боломжуудын талаарх мэдээллийг агуулсан уур амьсгалтай холбоотой ил тод байдлын тайлагнал**
  - ТУЗ ба гүйцэтгэх удирдлага
  - Уур амьсгалын эрсдэл, нөлөөллийн үнэлгээ
  - Шилжилтийн төлөвлөлт
  - Дасан зохицох стратеги
  - Эрсдэлийн удирдлага
  - Хүлэмжийн хий, эрсдэлд өртсөн багцын мэдээлэл (биет/шилжилтийн), ногоон зээлийн багцын дүн/харьцаа, эх үүсвэр, хөрөнгө оруулалтын хэмжээ

Source: IFRS Foundation

# Зах зээлийн нөхцөл байдал хувьсан өөрчлөгдөж байна

БОНЗ-той холбоотой үүрэг амлалтууд нь хэрэглэгчдийн худалдан авалт болон ажилчдын сонголтод гол үүрэг үүрэг гүйцэтгэх болсон

**... асуудлыг анхаардаг компаниас бараа бүтээгдэхүүн/үйлчилгээ худалдаж авах эсвэл компанид ажиллах сонирхолтой байна.**




Q: Please indicate how much you agree or disagree with the following statements.
Consumers (n=5,005) | Employees (n=2,510)
Source: PwC Consumer Intelligence Series June 2, 2021

# 1.2

# Монгол Улсын Тогтвортой санхүүгийн хөгжил

# Асуудал - бид ямар ирээдүйг хүсч байна вэ?





**Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, малчдын амьжиргаа**

# Асуудал - бид ямар ирээдүйг хүсч байна вэ?





**Хотжилт, буруу төлөвлөлт, агаар, хөрсний бохирдол, тэгш бус байдал**

# Асуудал - бид ямар ирээдүйг хүсч байна вэ?





**Дүрэм журмын хэрэгжилт сул, бизнесийн тогтворгүй үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын асуудал**

# Асуудал - бид ямар ирээдүйг хүсч байна вэ?






# Санхүүгийн байгууллагуудын хувьд гол шалтгаан юу байх вэ?

**III. Эерэг сөрөг тал**

- **Эерэг тал:**
- Харилцагч компанийн эрсдэл буурна
- Харилцагч компанийн үр ашиг нэмэгдэнэ
- Банк харилцагчийн хоорондын итгэлцэл нэмэгдэнэ
- Хөрөнгө оруулагч, харилцагчдын хүрээ тэлнэ (гадаад, дотоод)
- Зээлийн хүү буурна
- Урт хугацаанд тогтвортой хөгжинө
- **Сөрөг тал:**
- Харилцагчийг үргээнэ (богино хугацаанд)

# БОНЗ-той холбоотой эрсдэл




Нэр хүндийн эрсдэл




Зээлийн эрсдэл




Хуулийн эрсдэл

# Монгол Улс дах тогтвортой санхүүгийн хөгжил

**2013**

**1-Р ҮЕ ШАТ: ҮҮРЭГ АМЛАЛТ**

- Банкны салбарын хүлээсэн сайн дурын үүрэг амлалт
- Монголын Тогтвортой санхүүгийн зарчим ба удирдамж
- Мэдээлэл түгээх, мэдлэг, ойлголтыг сайжруулах

**2015**

**2-Р ҮЕ ШАТ: ХЭРЭГЖИЛТ**

- Тогтвортой санхүүгийн зарчмуудыг хэрэгжүүлэх
- БОНЗ эрсдэлийн удирдлагын тогтолцоог хөгжүүлэхэд чиглэсэн холбогдох бодлого, журам, эрсдэлийн үнэлгээний хэрэгслүүдийг боловсруулах
- Чадавх бэхжүүлэхэд чиглэсэн өргөн хүрээний үйл ажиллагаа
- Хяналт ба тайлагнал

**2018**

**3-Р ҮЕ ШАТ: ХАМРАХ ХҮРЭЭГ ӨРГӨТГӨХ**

- Ногоон таксономи
- ТоС Холбоо болон МНСК-г байгуулсан
- ББСБ-уудын сайн дурын үүрэг амлалт
- Хөрөнгийн зах зээлд тогтвортой санхүүгийн зарчимууд, гол элементүүдийг нэгтгэх

**2021**

**4-Р ҮЕ ШАТ: ХАМРАХ ХҮРЭЭГ УЛАМ ӨРГӨТГӨХ**

- Тогтвортой санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний замын зураг
- Тогтвортой санхүүг дэмжих бодлогын тогтолцоо
- Төрийн санхүүгийн тогтолцоонд нэгтгэх

**2030**

**5-Р ҮЕ ШАТ: МАНЛАЙЛАХ**

- Ногоон зээлийн багцыг банк болон ББСБ-уудын хувьд 10% ба 5%-д хүртэл тус тус нэмэгдүүлэх
- Тогтвортой санхүү нь санхүүгийн салбарын бүхий л үйл ажиллагаанд бүрэн тусгагдаж, Монгол Улс тогтвортой санхүүгийн чиглэлээр дэлхийд тэргүүлэгч болж хүлээн зөвшөөрөгдөх болно

Source: MSFA

# Монгол Улс дах тогтвортой санхүүгийн хөгжил

1. Таатай орчин, тогтолцоо (сайн дурын болон зохицуулалтын)

**1.1 Гол бодлого, тогтолцоонууд**

- МБХ болон ОУСК-ийн хамтран боловсруулсан Монголын тогтвортой санхүүгийн зарчмууд (2015 ба 2023)
- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг (2018 ба 2022)

**1.2 БОНЗ эрсдэлийн удирдлага**

- МБХ-ноос гаргасан БОНЗ эрсдэлийн удирдамж (2015)
- Монголбанк болон СЗХ-наас баталсан БОНЗ эрсдэлийн удирдлагын заавар (2022 ба 2023)

**1.3 Тогтвортой санхүү**

- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан Ногоон ба Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн үйл ажиллагаануудын ангилал, таксономи (2018 ба 2023)
- СЗХ-ноос баталсан Ногоон бонд гаргах бүртгүүлэх журам (2011)
- Жендэрийн санхүүжилтийн бодлого (2022)

**1.4 Монголбанкнаас гаргах Уур амьсгалын эрсдэлийн удирдамж (2023-2024)**

**1.5 Тайлагнах, ил тод байдлын зааварчилгаа**

- БОНЗ тайлагналын удирдамж (2022)
- TCFD тайлагналын удирдамж (2023)

Эх сурвалж: ToC холбоо

**2. Засаглал**

2.1 Хувийн хэвшлийн манлайлал

2.2 Улс төрийн манлайлал

2.3 Бодлого батлах, хяналт тавих

**3. Дэмжих дэд бүтэц**

3.1 Үнэлгээ ба судалгаа:
- Суурь судалгаа, зах зээлийн үнэлгээ

3.2 Хэрэгсэл, заавар, бодлогын загвар, дүн шинжилгээ хийх хэрэгсэл:
- Бодлогын загвар, дүн шинжилгээ хийх хэрэгсэл

3.3 Бодлогын урамшуулал/хяналтын арга хэмжээ:
- Шагнал, ногоон своп, хүүгийн татаас

3.4 Чадавхи бэхжүүлэх болон ойлголтыг сайжруулах:
- Цахим сургалтын платформууд, тэнхимээр хийх сургалтууд

3.5 Бүтээгдэхүүн хөгжүүлэлт ба туршилтууд:
- Эрчим хүчний хэмнэлттэй орон сууц, ноолуур, хөдөө аж ахуй гэх мэт.

3.5 Хяналт, тайлагнах, шалгах:
- Жилийн үнэлгээ

**4 Санхүүгийн бүтээгдэхүүнүүд**

4.1 Ногоон болон нийгмийн зээл

4.2 Ногоон бонд

4.3 Ногоон нөлөөллийн сан ба даатгал

**5 Санхүүгийн зуучлагчид**

5.1 Санхүүгийн байгууллагууд

5.2 Монголын ногоон санхүүжилтийн корпораци

5.3 Тэрбум модны сан

Эх сурвалж: ToC холбоо

# Бусад гол бодлого, баримт бичгүүд

**Монгол Улсын Тогтвортой санхүүгийн зарчмууд болон Үндэсний тогтвортой санхүүгийн замын зураг**



**БОНЗ Эрсдэлийн удирдлагын удирдамж (банкнууд болон ББСБ-ууд)**




**Ногоон таксономи**




**Тогтвортой хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаануудын ангилал, таксономи**




**Жендэрийн санхүүжилтийн тогтолцоо ба хэрэгслүүд**




**Ногоон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх замын зураг**




**Ногоон бонд гаргах бүртгүүлэх журам**



**БОНЗ тайлагналын удирдамж**

Эх сурвалж: ToC холбоо

# Таксономи

**Ангиллууд:**

1. Эрчим хүчний үйлдвэрлэл ба холбогдох дэд бүтэц
2. Эрчим хүчний хэмнэлт
3. Тогтвортой хотжилт ба орон сууц
4. Бохирдлоос урьдчилан сэргийлэх, хянах
5. Усны тогтвортой хэрэглээ
6. Тогтвортой хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал
7. Тогтвортой газар ашиглалт, ойн аж ахуй, биологийн олон янз байдлыг хамгаалах, эко аялал жуулчлал
8. Нүүрс төрөгчийн хий бага ялгаруулдаг тээвэр
9. Мэдээлэл, харилцаа холбоо, технологи
10. Эрүүл мэнд
11. Боловсрол ба соёл
12. Орлогод нийцсэн дэд бүтэц




**51**
**Sub-category**

**137**
**Activities**

**80+**
**Organizations provided their comment**

**150+**
**Organizations participated in the consultations**

# Таксономи

## Жишээлбэл: Тогтвортой ус ба хог хаягдал

| Ангилал | Дэд ангилал | Үйл ажиллагаа | Жишээ үйл ажиллагаа | ТХЗ | Нөлөөллийн үзүүлэлт | Шалгуур | Баталгаажуулалт | Үндэсний стандарт | ОУ стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5. Тогтвортой ус ба хог хаягдал | 5.2 Хог хаягдал | 5.2.4 Үйлдвэр, бизнес болон гэр ахуйн хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, нөхөн сэргээх | Үйлдвэр, бизнес болон гэр ахуйн хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, нөхөн сэргээхэд чиглэсэн холбогдох машин, тоног төхөөрөмж, технологийг үйлдвэрлэх, борлуулах | 6.3, 6.6 9.4 13.1 14.1 15.1 | 1. Зохих стандартын дагуу дахин боловсруулсан хог хаягдлын хэмжээ<br>2. Хог хаягдлын хорт нөлөөнд өртсөн хүмүүсийн тоо, хүйс<br>3. Зардлын хэмнэлт<br>4. Дахин боловсруулсан, дахин ашигласан, нөхөн сэргээсэн хог хаягдлаас үүсэх хүлэмжийн хийг бууруулах тооцоолол | | Хэрэгжилтийн өмнөх: Суурь үнэлгээ/Хог хаягдлын аудит Хэрэгжилтийн дараах: Жилийн явцын тайлан<br><br>Үнэлгээний стандарт/хэрэгсэл: ТоС холбооноос боловсруулсан үнэлгээний хэрэгсэл, техник эдийн засгийн үндэслэл, БОН эрсдэлийн нөлөөллийн үнэлгээ | Хог хаягдлын тухай хууль | ISO 9001, ISO 14001. ISO 45001 |

# Ногоон зээл олгох үйл явц

ТоС Холбоо

1. Банкны ерөнхий шаардлагыг хангаж буй эсэхийг шалгах
2. Зээлийн зориулалт ногоон мөн эсэхийг шалгах
3. Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн үнэлгээ хийх
4. Ногоон зээлийн шалгуурыг хангаж буй эсэхийг шалгах, нөлөөллийг урьдчилсан байдлаар хэмжих
5. Ногоон зээл олгох
6. Явцын нөлөөллийн хяналт хийх
7. Үр нөлөөг тайлагнах

## GREEN LOAN PRINCIPLES

1. **Use of proceeds**
   *Outlines how proceeds from a green loan must be used*
2. **Process for project evaluation and selection**
   *Outlines how borrowers should communicate their green objectives*
3. **Management of proceeds**
   *Lenders must ensure proceeds are used for green initiatives*
4. **Reporting**
   *Lenders should track the proceeds of a green loan*

*Source:* LMA Loan Market Association

MSFA

# Ногоон зээлийн бүтээгдэхүүний боломж

ToC Холбоо

MSFA

### Retail banking

- Green mortgage
- Green consumer loans
- Green car lease
- Credit card

### Corporate banking

- Green project finance
- Carbon finance
- Green corporate Loans
- Green securitization



### Investment banking

- Green savings
- Sustainable investment
- Green Funds
- Green bonds

### Insurance

- Electric car insurance
- Catastrophe insurance
- Green insurance
- Insurance for Renewable Energy Projects

# Үр дүнг хэмжих




**1. ТоС холбооноос гишүүдийнхээ үйл ажиллагааны гүйцэтгэлд үнэлгээ хийх, оноо өгөх**




**2. Монголбанк, СЗХ-ны ногоон зээлийн хяналтын самбар**




**3. Олон улсын жишиг ба үнэлгээ (ТБСБХ-ны тайлан)**

Эх сурвалж: ТоС холбоо

# ТоС-ийг хэрэгжүүлэх амбиц

## ТоС-ийг хэрэгжүүлснээр банкинд үүсэх боломжууд




Эх сурвалж: PwC

IFC International Finance Corporation WORLD BANK GROUP

ТоС MONGOLIAN SUSTAINABLE FINANCE ASSOCIATION

# Сайн санааны үзүүрт ТоС!

